



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/65

Төгөл

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Худалдаа, нийтийн үйлчилгээний газар 1 иргэнд 348м² эзэмшүүлсэн газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан тул хүсэлтийн дагуу хавсралтаар хугацааг сунгаж эзэмшүүлсүгэй

2. Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын захирамжийн хавсралтын холбогдох заалтуудыг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэдийн газар эзэмших эрхзүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Ө.Нямхишиг)-д зөвшөөрсүгэй.

4. Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР



9072204 6715114494